



НӨЛӨӨЛЛИЙН ТАЙЛАН **2025**



Агуулга

Удиртгал	3
Багцын тойм	6
Нөлөөллийн гол үзүүлэлтүүд	7
Нөлөөллийн зорилго: Санхүүгийн хүртээмж	10
Санхүүгийн хүртээмжийн шагнал	13
Харилцагчдын түүх	15
Санхүүгийн боловсрол	18
Харилцагчийг хамгаалах зарчим	19
2X Challenge-г хангав	20
Дүгнэлт	21



Компанийн тухай

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь Монгол Улсын зах зээлд технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хослуулсан финтек бизнес моделийг ЛэндМН аппликейшнээр дамжуулан нэвтрүүлж, барьцаагүй, хямд өртөгтэй, бүрэн дижитал хэрэглээний зээлийн үйлчилгээг үзүүлдэг байгууллага юм.

2024 оноос эхлэн ЛэндМН стратегийн чиглэлээ хэрэглээний зээлээс бизнесийн зээл рүү шилжүүлж, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд (БЖДБЭ) чиглэв. Монгол Улсын эдийн засагт бодит хувь нэмэр оруулдаг ч албан ёсны санхүүгийн тогтолцоонд бүрэн хамрагдаж чаддаггүй эдгээр бизнес эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бид түлхүү анхааран ажиллаж байна.

ЛэндМН нь үйл ажиллагаандаа ил тод байдал, хариуцлагатай санхүүжилтийн зарчмыг баримталж, зөвхөн зээл олголтоор хязгаарлагдахгүйгээр харилцагчдад үзүүлж буй нийгэм, эдийн засгийн нөлөөллийг тогтмол хэмжих, үнэлэхэд анхааран ажиллахыг эрхэмлэдэг.

Түүнчлэн байгууллагын үнэт зүйл, зорилготой нийцсэн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллаж, Монгол Улсын санхүүгийн тогтолцоог илүү хүртээмжтэй, ил тод, тогтвортой болгоход хувь нэмрээ оруулахыг зорин ажиллаж байна.



Удирдлагын мэндчилгээ

2025 он нь ЛэндМН-ийн хөгжлийн замналд онцгой ач холбогдолтой жил байлаа. Энэ нь бид хамтдаа суралцан, өсөж хөгжсөнөөс гадна байгууллагынхаа хариуцлагыг улам гүнзгий ухамсарласан жил болсон гэж харж байна. Монголын БЖДБ эрхлэгчид эдийн засагт тэгш оролцох боломжтой байх ёстой гэсэн үнэт зүйл маань бидний үйл ажиллагааны цөмд оршдог. Энэхүү итгэл үнэмшил нь бид бүтээгдэхүүнээ хэрхэн зохион бүтээх, шийдвэрээ хэрхэн гаргах, амжилтаа ямар хэмжүүрээр үнэлэхийг тодорхойлсоор ирсэн билээ.

2024 онд бид Монгол Улсад анх удаа бизнесийн зээлийг гар утсаараа ердөө 5 минутын дотор, барьцаагүй, бүрэн дижитал хэлбэрээр авах боломжийг нэвтрүүлсэн нь томоохон дэвшил болсон. Хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн онооны систем бүхий уг бүтээгдэхүүн нь зээлийн хүсэлтийг бодит цаг хугацаанд боловсруулж, шуурхай шийдвэр гарган, харилцагчид санхүүжилтээ даруй авах боломжийг бүрдүүлсэн юм. Ингэснээр санхүүжилт авахад тулгардаг түгээмэл саад болох барьцаа хөрөнгийн шаардлага, удаан шийдвэр гаргалт, салбар дээр очих хэрэгцээ зэрэг асуудлуудад оновчтой шийдэл болж чадсан.

Flexi Бизнес зээлийг 2024 онд нэвтрүүлснээс хойш нийт 133 мянган удаагийн зээлийг олгож, 439 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улс орон даяарх бизнес эрхлэгчдэд хүргэжээ. Тус бүтээгдэхүүн 2024 оны IV улиралд нийт зээлийн багцын 23 хувийг бүрдүүлж байсан бол 2025 оны IV улиралд 38 хувьд хүрч өссөн байна. Энэхүү өсөлт нь

бидний санхүүжилтийн хүртээмж тэлж, мянга мянган бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа, өсөлт хөгжил, тогтвортой байдлыг бодитоор дэмжиж байгааг илтгэж байна.

2025 онд бид санхүүжилтийнхээ нөлөөллийг илүү системтэйгээр хэмжиж эхэлсэн. Ингэхдээ зөвхөн хэдэн хүнд, хэдий хэмжээний санхүүжилт олгосон тоон үзүүлэлтээр хязгаарлагдахгүй, харин уг санхүүжилт нь бизнесийн өсөлт, орлогын тогтвортой байдал, өрхийн сайн сайханд хэрхэн бодитоор нөлөөлж байгааг үнэлэхэд онцгойлон анхаарлаа хандуулсан. Үүний үндсэн дээр бид анхны "Нөлөөллийн тайлан" (Impact Report)-г нийтэлж байгаадаа баяртай байна. Энэхүү тайлан нь манай байгууллагын хариуцлага, ил тод байдал, нотолгоонд суурилсан нөлөөллийн удирдлагыг бэхжүүлэх анхны бөгөөд чухал алхам болж байна.

Цаашид бид санхүүгийн гүйцэтгэлийг нийгмийн эерэг үр дүнтэй уялдуулан урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгодоо үнэнч хэвээр байх болно. Хариуцлагатай инновацыг тууштай нэвтрүүлж, харилцагчид болон түншүүдтэйгээ нягт хамтран ажилласнаар Монгол Улсын хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг дэмжих хувь нэмрээ улам гүнзгийрүүлэхийг зорьж байна.

Энэхүү замналд бидэнтэй хамт байж, тууштай итгэл хүлээлгэн дэмжиж ирсэн Та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Тогтвортой хөгжлийн замнал

• **2017**

Бүрэн дижитал платформоор дамжуулан хэрэглээний зээлийн үйлчилгээг санал болгож, үйл ажиллагаагаа эхлүүлэв.

• **2021**

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ToC)-ны гишүүнээр элсэж, хариуцлагатай санхүүжилтийн зарчмуудыг хэрэгжүүлэх аяллаа эхлүүлэв.

• **2024**

Компани стратегийн түвшинд үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг БЖДБ-үүдэд зээл олгоход төвлөрүүлэв. ЛэндМН нь БЖДБЭ нарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор барьцаагүй, хурдан, бүрэн дижитал Flexi Business зээлийг зах зээлд нэвтрүүлэв.

• **2025 оны 5 дугаар сар**

БОНЗ ба Эрсдэлийн хороог байгуулж, засаглал, хяналт болон тогтвортой байдлын асуудлыг шийдвэр гаргалтад нэгтгэх үйл явцыг бэхжүүлэв.

• **2024 оны 12 дугаар сар**

ЛэндМН нь анхны дотоод Тогтвортой байдлын тайлангаа боловсруулж, нөлөөллийн хэмжилтийг системтэй хийх болон суурь үзүүлэлт тогтоох чухал алхмыг хийв.

• **2024 оны 8 дугаар сар**

ЛэндМН нь Тогтвортой байдлын бодлогоо албан ёсоор баталж, Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмуудыг компанийн бизнесийн хүрээнд системтэйгээр нэгтгэн хэрэгжүүлж эхлэв.

• **2025 оны 5 дугаар сар**

ЛэндМН нь IFC (International Finance Corporation)-тэй нийцсэн Хориглох жагсаалтыг (Exclusion List) баталж, хариуцлагатай, ёс зүйтэй зээл олголтын бодлогоо улам бэхжүүлэв.

• **2025 оны 12 дугаар сар**

Анхны Нөлөөллийн тайланг нийтлэв.

Бизнес зээлийн багцын тойм

Нийт олгосон зээлийн хэмжээ:

439 тэрбум

(төгрөг)

Нийт олгосон зээлийн тоо:

133 мянга

Зээлийн дундаж хэмжээ:


7.8 сая

(төгрөг)

Идэвхтэй харилцагчдын тоо:

10 мянгаас дээш

Санхүүжүүлсэн салбарын ангилал



Харилцагчдын сэтгэгдэл

2024 онд ЛэндМН нь уян хатан нөхцөл бүхий “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг **эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих** зорилгоор зах зээлд анхлан нэвтрүүлсэн. Энэхүү бүтээгдэхүүн нь харилцагчдын зүгээс өндөр үнэлгээ авч, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн хүндрэлүүдийг даван туулахад бодит дэмжлэг үзүүлж байна. Харилцагчдын эерэг сэтгэгдэл, бодит туршлагууд нь бидний бий болгож буй нөлөөллийг илтгэх эхний үзүүлэлт болж, цаашдын үйл ажиллагаанд урам зориг, итгэл өгдөг билээ. Тус зээлийн бүтээгдэхүүнийг ашиглан бизнесээ өргөжүүлж, санхүүгийн саадыг даван туулсан харилцагчдын сэтгэгдлээс хүргэж байна:

Voices from our customers:



Барьцаа хөрөнгө, насны хязгаар, батлан даалт гээд л их юм болдог. ЛэндМН хамгийн анх нээгдэхэд нь л түншилж эхэлсэн. Хурдан шуурхай, найдвартай, одоо Flexi зээл маш үр дүнтэй бизнес эрхэлдэг бидэнд цаг үеэ олсон уян хатан амар зээл. Та бүхний цаашдын ажилд нь амжилт хүсье.



Uhaan Zaya



Бидэнд итгэл үзүүлж, үнэ цэнтэй боломжуудыг олгож байгаад ЛэндМН-ийн хамт олондоо чин сэтгэлээсээ талархаж байна. Тогтмол дэмжлэг үзүүлдэгт баяртай байна. Би Flexi зээлийг ашигладаг бөгөөд маш хурдан, үр ашигтай байдаг. Танай хамт олонд цаашдын амжилтыг хүсье.



Ujii Ujii



Сайн байна уу, танай хамт олонд маш их баярлалаа. Өдөр тутмын үйл ажиллагаагаа өргөжүүлж, илүү олон ажлын байр бий болгоно гэдэг өмнө нь зүүд мэт санагддаг байлаа. Flexi Business зээлээр дамжуулан бид 73 сая төгрөгийн санхүүжилт авсан. Бид хоёр шинэ ажилтан авч, шаардлагатай тоног төхөөрөмжөө худалдан авч, эхний захиалгуудаа амжилттай гүйцэтгэж эхлээд байна. Чин сэтгэлээсээ талархаж байна.



Altaa Altaa



Танай хамт олонд цаашдын ажилд нь амжилт хүсье. Надад итгэл үзүүлж, ирээдүйд минь хөрөнгө оруулалт хийсэнд би үнэхээр талархаж байна. Би 50,000 төгрөгөөс эхэлж байсан. Цаг хугацаа маш хурдан юм аа, одоо бизнес улам өргөжиж байгаа. Үнэхээр өгөөжтэй. Ямар ч банк итгэж надад зээл гаргаагүй байхад танай хамт олон надад барьцаагүй зээл олгож үнэхээр амьдралыг минь өөрчилсөнд чин сэтгэлээсээ талархаж байна.



Hishigbayar Hb



Танай байгууллага үнэхээр боломж олгосон сайхан үйлчилгээг итгэл хүлээлгэн гоё боломжуудыг олгож буйд талархдаг шүү. Улам их өргөжүүлж байгаад баярлаж бизнес өргөжүүлье гэхээр барьцаа хөрөнгө, бөөн баримт бичиг нэхдэг асуудал их тулгардаг. Энэ бүх боломжийг нээж итгэл олгодог танай хамт олонд илүү их амжилт хүсье.



Tsolmontuya Narmandakh




Дийлэнхдээ их хэмжээний бичиг баримт, төвөгтэй шаардлага тавьдаг бол танай хамт олон үйл явцыг энгийн байлгаж, хэт олон шаардлага тавьдаггүй. Танай байгууллагад үнэхээр их баярлаж байна. Ажил үйлсэд тань цаашдын амжилтыг хүсье.



Puujee Puujee



2025 оны нөлөөллийн тойм – БЖДБ эрхлэгчид




2025 оны нөлөөллийн тойм – БЖДБ эрхлэгчид

Бизнес зээл нийт багцын **38%**-ыг эзэлж байна.

Санхүүгийн үйлчилгээний харилцагчид **41%**

Бичил бизнес эрхлэгчид **74%**

Шалтгаанууд:




Залуу бизнес эрхлэгчид (<35) **36%**

Санхүүжилтийн дараа арлого/борлуулалт нь нэмэгдсэн харилцагчид **92%**

Давтан зээлдэгчид **46%**

Ажилтны тоо 5-с бага харилцагчид **87%**

Санхүүжилтийн дараа ажилчдын тоо нэмэгдсэн харилцагчид **36%**



Нөлөөллийн зорилго: Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх



Удиртгал:

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр Монгол Улсад 2025 оны байдлаар 223,000 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. Гэвч эдгээрээс ердөө 90,000 орчим нь л санхүүгийн байгууллагаас бизнесийн зээл авч, үйл ажиллагаандаа хөрөнгө оруулж байгаа бол үлдсэн 133,000 гаруй БЖДБ эрхлэгчид санхүүжилтийн хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгаа нь тэдний бизнесээ тогтвортой авч явах, цаашид үйл ажиллагаагаа тэлэх боломжийг хязгаарлаж байна.

БЖДБ эрхлэгчид Монгол Улсын эдийн засагт идэвхтэй хувь нэмэр оруулж байгаа хэдий ч албан ёсны санхүүгийн тогтолцоонд бүрэн хамрагдаж чадахгүй хэвээр байна. Үүнд орлогын урсгалын тогтворгүй байдал, барьцаа хөрөнгийн хангалтгүй байдал, зээлийн түүхгүй байдал зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлдөг.

Эдгээр саад бэрхшээл нь ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн болон хязгаарлагдмал нөөц бололцоотой бизнес эрхлэгчдэд илүү сөргөөр нөлөөлдгийг үгүйсгэх аргагүй. Учир нь эдгээр бүлгийн хувьд өмч хөрөнгө өөрийн нэр дээр бүртгэлгүй байх, зээлийн түүх багатай байх, үүнээс шалтгаалан нэмэлт баталгаа, барьцаа шаардагдах зэрэг хүндрэл түгээмэл байдаг. Түүнчлэн тэд харьцангуй бага хэмжээний зээл хүсдэг нь санхүүгийн байгууллагуудын хувьд сонирхол багатай сегментэд тооцогдох, мөн газарзүйн байршлаас шалтгаалсан хүртээмжийн хүндрэл зэрэг нэмэлт саадтай тулгардаг билээ.

Санхүүгийн үйлчилгээ хангалттай хүрч чадахгүй байгаа эдгээр бүлгүүдэд илүү тэгш, хүртээмжтэй шийдлийг хүргэж, санхүүжилтийн зөрүүг бууруулах нь бидний үйл ажиллагааны хамгийн гол зорилго юм. Бид барьцаа хөрөнгөд тулгуурласан уламжлалт санхүүжилтийн оронд бизнесийн орлогын гүйцэтгэлд суурилсан, хиймэл оюун ухааны дэмжлэгтэй үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж, бүрэн дижитал платформуор дамжуулан санхүүжилт олголтыг хялбаршуулж байна. Ингэснээр бид дээрх дурдсан бүлэг бизнес эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж чадаж байна.

Хэдийгээр олон хүнд хүрч ажиллах нь санхүүгийн хүртээмжийг тэлж буйн нэг илрэл мөн ч гэсэн бидний хувьд санхүүгийн хүртээмж гэдэг нь зөвхөн зээлийн хүрээгээ тэлэх ойлголт биш юм. Харин бизнес эрхлэгчдийг хөгжлийн бүхий л үе шатанд нь дэмжиж, тогтворжих, өсөх, цаашид тогтвортой өргөжих боломжийг бүрдүүлэхийг хэлнэ.

Иймээс бид харилцагчдын бодит хэрэгцээнд тулгуурлан дараагийн шатны үйлчилгээ, зорилтот шийдлүүдийг тасралтгүй хөгжүүлж, энгийн зээл олгогч бус харин урт хугацааны түнш байхыг зорьдог. Ингэснээр бид бодит бизнесийн өсөлтийг хэмжигдэхүйц байдлаар дэмжиж, Монгол Улсад санхүүгийн хүртээмжийг бодитоор ахиулахад хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Зорилтот сегмент (2 ба түүнээс дээш) бүхий БЖДБ-д олгосон нийт харилцагчид:

6.8 мянга

(Нийт харилцагчдын 64%)


Зорилтот сегмент (2 ба түүнээс дээш) бүхий БЖДБ-д олгосон нийт зээлийн багцын үлдэгдэл:

53.9 тэрбум (төгрөг)


(Нийт үлдэгдлийн 43%)

Нөлөөллийн зорилтот сегментүүд

Харилцагчдыг хүйс, байршил, нас, орлогын түвшнээр нь:



БЖДБ-ийн хэмжээ болон орлогын түвшнээр нь:



Нөлөөллийн зорилго: Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Бизнесд үзүүлэх нөлөөлөл



Нөлөөллийг хэмжсэн аргачлал:


Санхүүжилт олгосны дараа харилцагчид уг санхүүжилтийг хэрхэн ашиглаж байгаа, мөн энэ нь тэдний бизнесийн үйл ажиллагаанд бодитоор хэрхэн нөлөөлж байгааг нотолгоонд суурилан тодорхойлох нь санхүүгийн байгууллагуудын хувьд сорилт болдог. Учир нь зээлийн ашиглалт болон үүний үр дүнд бий болох нөлөөлөл нь харилцагчдын өөрсдийн шийдвэр, бизнесийн үйл ажиллагаанаас шууд хамаардаг бөгөөд бэлэн өгөгдөл дээр үндэслэн хэмжих боломж нь ихэвчлэн санхүүгийн байгууллагын өгөгдөл мэдээллийн хүрээнээс давсан байдаг.

Иймээс энэхүү төрлийн нөлөөллийн хэмжилт нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарт харьцангуй шинэ бөгөөд анхдагч алхмуудын нэг болж байна.


Энэхүү тайлангийн хүрээнд бид санхүүжилтийн үр дүнг хэмжих анхны оролдлогоо хийж, өөрсдийн тодорхойлсон нөлөөллийн гол үзүүлэлтүүдэд суурилсан судалгааны аргыг ашигласан.

Тайланд тусгагдсан бүх мэдээлэл нь уг судалгаанд оролцсон харилцагчдын өгсөн хариултууд дээр үндэслэсэн болно. Цаашид нөлөөллийг илүү бүрэн, нарийвчилсан байдлаар хэмжих зорилгоор дижитал системд суурилсан мэдээлэл цуглуулах аргачлалыг хөгжүүлж, илүү өргөн хүрээний өгөгдөл цуглуулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.


Ажилчдын тоо:




Ажлын байр нэмэгдүүлсэн байдал:



Зээл олголтын дараа бизнесийн орлого/борлуулалт өссөн үзүүлэлт



Зээл олголтын дараа бизнесд үзүүлсэн бодит өөрчлөлт



Нөлөөллийн зорилго: Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Өрхөд үзүүлэх нөлөөлөл




Өрхөд үзүүлэх нөлөөлөл:

Манай харилцагчдын дунд бизнес эрхлэгчдийн 67% нь ердөө 1–2 ажилтантай байдаг нь тэдний бизнес бичил, жижиг хэмжээтэй бөгөөд өрхийн амьдралтай нягт холбоотой байдгийг харуулж байна.

Иймээс бид судалгаагаа зөвхөн бизнесийн гүйцэтгэлээр хязгаарлахгүй, илүү өргөн хүрээнд авч үзсэн. Тодруулбал, бизнесийн өсөлт нь харилцагчдын хувийн санхүү болон өрхийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг мөн үнэлсэн. Ингэснээр бидний хэмжилт нөлөөллийг илүү бодит, амьдралд ойр, практик түвшинд тодорхойлох боломжийг бүрдүүлж байна.

Мөн ийм төрлийн хэмжүүрүүд нь олон улсын нөлөөллийн үнэлгээ хийдэг байгууллагууд болон хөрөнгө оруулагчид компани нийгэмд эерэг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг үнэлэхдээ анхаарч үздэг чухал шалгууруудын нэг болдог.

Өрхөд амьдралд гарсан өөрчлөлт



- Байр, орон сууц, амьдрах нөхцөл сайжирсан
- Хүүхдийн боловсролд зарцуулж буй зардал нэмэгдсэн
- Хүнсний бүтээгдэхүүн болон хэрэглээний барааны чанарт илүү анхаарах боломж нэмэгдсэн
- Эрүүл мэндийн зардлыг даах чадамж нэмэгдсэн
- Бусад (сэтгэлзүйн тайван байдал нэмэгдэх, санхүүгийн стресс буурах)

Хувийн санхүүд гарсан өөрчлөлт



Тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулж буй хувь нэмэр

- 1 NO POVERTY** Санхүүгийн үйлчилгээний тэгш хүртээмж: Нийт 133 мянган зээлээр 439 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор санхүүгийн үйлчилгээний хүртээмж багатай бизнес эрхлэгчдийг албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамруулжээ.
- 5 GENDER EQUALITY** Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхжуулалт: Манай харилцагчдын ойролцоогоор 72% нь эмэгтэйчүүд бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийн боломж, чадавхийг нэмэгдүүлж байна.
- 8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH** Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт: Харилцагчид бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ажилтнуудын тоо ойролцоогоор 36%-иар нэмэгдсэнээр ажлын байр бий болгож, амьжиргааг дэмжиж байна.
- 9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE** Үйлдвэрлэл, инновац ба дэд бүтэц: Харилцагчид бизнесээ ойролцоогоор 38%-д нь шинэчилж, өргөтгөн сайжруулснаар үйлдвэрлэл, бизнесийн чадавхыг улам бэхжүүлж байна.

lendmn | flexibusiness

20 24 | Fintech Excellence Awards

Financial Inclusivity



Санхүүгийн хүртээмжийн манлайлал

ЛэндМН-ийн хувьд санхүүгийн хүртээмж нь ангид хэрэгжүүлж буй санаачилга бус, харин компанийн үндсэн бизнесийн загварт бүрэн шингэсэн суурь зарчим юм. Бүрэн дижитал, барьцаагүй финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд бид зээлийн системээ анхнаасаа хүртээмжтэй байдлыг хангахаар загварчилж, уламжлалт санхүүгийн үйлчилгээ авахад тулгардаг бүтцийн саад бэрхшээлүүдийг бууруулахыг зорьж ирсэн.

Энэхүү зарчмыг хамгийн тод илэрхийлж буй бүтээгдэхүүн нь “Flexi Business” бөгөөд уг бүтээгдэхүүн нь олон улсын түвшинд ч үнэлэгдэн хүлээн зөвшөөрөгдсөн юм.

“Flexi Business” бүтээгдэхүүн нь Сингапурын Мөнгөний газар (Monetary Authority of Singapore) болон Singapore FinTech Association-оос хамтран зохион байгуулдаг Financial Inclusivity Award-д финалист-аар шалгарсан. Энэхүү үнэлгээ нь Зүүн Өмнөд Ази болон бусад бүс нутгийн хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг онцлон үнэлсэн чухал амжилт болсон юм.



Харилцагчдын бодит түүхээс



Найман нэрийн дэлгүүр эрхлэгч:

Манай дэлгүүрийн үйл ажиллагаа 2016 онд Гандангийн орчимд 8 нэрийн жижиг дэлгүүрээс эхэлсэн. Хэдэн жил завсарласны эцэст одоогийн байршилдаа дахин 8 нэрийн дэлгүүрээ нээн ажиллуулж эхэлсэн. Нийтдээ энэ салбарт 7–8 жил ажиллаж байна.

Хүнсний дэлгүүрийн хувьд бараагаа ихэвчлэн сарын эхээр зээлээр татаж, сарын сүүлээр борлуулалтаасаа төлдөг онцлогтой. Нэг удаа сарын сүүлээр мөнгө дутмаг болж, “ЛэндМН-ээс дахин зээл авч болох болов уу” гэж бодоод дансны хуулгаа явуулж хүсэлт гаргасан. Тэгэхэд зээл ямар ч асуудалгүй хурдан орж ирж, барааныхаа төлбөрийг төлж чадсан нь маш их нэмэр болсон.

Одоо бол зээлээрээ эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлж, дэлгүүрийн бараа таталтаа сайжруулж байна. Хүнсний дэлгүүр олон нэр төрлийн бараатай байж, сонголт их байх тусам борлуулалт сайжирдаг. Энэ дэлгүүр өмнө нь үйлчлүүлэгчээ их алдчихсан байсан газар.

Харин одоо хүмүүсийн ам сайтай, байнга ирж үйлчлүүлдэг болсон. Зөвхөн манай байрны оршин суугчид ч биш, ойр хавийн өөр байрнуудаас хүртэл хүмүүс ирж үйлчлүүлдэг болсон. Үүний гол шалтгаан нь орлого нэмэгдэж, бараа таталт сайжирснаар хэрэглэгчдэд илүү олон сонголт санал болгож чаддаг болсонтой холбоотой гэж боддог.

Өнгөрсөн 12-р сард бензин олдохгүй ховордсон үед олон айл өрхийн амьдрал хүндэрч, тэр нь манай борлуулалтад ч мэдэгдсэн. Тэр үед, 11-р сард ч мөн адил үйлчлүүлэгч цөөрч, орлого багассан үе байсан. Ийм үед сарын сүүлээр мөнгө дутмаг болоход дахин ЛэндМН-д хандаж асуудлаа шийдэж чаддаг нь их дэмжлэг болдог.

Ер нь ЛэндМН-д маш их сэтгэл хангалуун байдаг. Үнэхээр бизнес эрхэлж байгаа хүмүүст өгөөжтэй, бодит дэмжлэг болдог гэж боддог.

Эмэгтэй хувцасны дэлгүүр эрхлэгч:

Ковид -ийн өмнөхөн хувцас зарж үзмээр санагдаад ээжээсээ 800,000 төгрөг зээлж, тэр мөнгөндөө тааруулан Хятадаас цамц оруулж ирж зарж эхэлсэн. Эхэндээ гэрээсээ онлайнаар зарж үзсэн бөгөөд боломжийн борлуулалттай байхаар нь зарын group-үүдээр дамжуулан борлуулж эхэлсэн. Дараа нь олсон орлогоороо Gemmall-д 30 м² талбайтай дэлгүүр түрээслэж аваад, мөн Maxmall-д нэг дэлгүүр нээсэн. Гэхдээ хоёр дэлгүүрийг зэрэг дүүрэн бараатай байлгах нь нэлээд хэцүү байсан.

Тэр үед ЛэндМН-ээс зээл авч үзэхээр шийдэж, дансны хуулгаа уншуултал шууд хангалттай хэмжээний зээлийн эрх үүссэнд үнэхээр гайхаж байсан. Тэр зээлээрээ Турк руу явж бараагаа татан авчирсан. Ямар ч барьцаагүй, хэдхэн минутын дотор зээл олгосон нь миний бизнесийг хөгжүүлэхэд маш том дэмжлэг болсон.

Авсан зээл маань дэлгүүрийн салбараа өргөжүүлэхэд төдийгүй өрхийн амьдралд маш их эерэг нөлөө үзүүлсэн. Барааны чанар, сонголт сайжрах тусам орлого нэмэгдэж, амьдралын чанар ч мэдэгдэхүйц дээшилсэн. Одоо хувийн болон гэр бүлийн зардалд ямар нэгэн хүндрэл гарахаа больсон.

Бизнесээ эхэлж хийж байхад бараг нэг ч өдөр амралгүй ажилладаг байсан тул мэдрэлийн архаг ядаргаанд хүртэл орж байсан. Харин одоо ажилчидтай болж, ажлын ачаалал хөнгөрсөн тул өөртөө цаг гаргах боломжтой болсон. Мөн өмнө нь хүргэлтээ өөрөө хийдэг байсан бол одоо хүргэлтийн компанитай хамтран ажилладаг болсон. Зөвхөн дэлгүүрт маань нөлөөлөхөөс гадна цаашлаад миний хувийн амьдралдаа сэтгэл хангалуун байдаг болсонд маань ЛэндМН хувь нөлөө үзүүлсэн гэж бодож байна.



Харилцагчдын бодит түүхээс

2026



Хүүхэд сурган хүмүүжүүлэх төвийн эрхлэгч

Сургуулийн

өмнөх боловсролын салбарт 13 жил ажиллаж байна. Ээж маань цэцэрлэгийн багш байсан тул би багаасаа цэцэрлэгийн орчинд өссөн бөгөөд хүүхдийн байгууллагад ажиллах, цэцэрлэг байгуулах хүсэл маань эртнээс бий болсон гэж боддог.

Одоогийн үйл ажиллагаа явуулж буй барилга анх ахын минь эзэмшлийн, зочид буудлын зориулалттай байр байсан. Үүнийг хүүхдэд зориулсан орчин болгон өөрчлөн цэцэрлэгийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Манай орчимд цэцэрлэгийн хүрэлцээ хомс тул хүүхдүүдийг хамруулах хэрэгцээ өндөр байдаг.

Анх 2012 онд 1 давхар, 3 бүлэгтэй, 35 хүүхдийн хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн бол одоо 8 бүлэгтэй, 200 хүүхдийн хүчин чадалтай болж өргөжин ажиллаж байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх явцдаа банкны зээл авч байсан бөгөөд тухайн үед финтек, аппликэйшнээр зээл авах боломж байгаагүй. Дараа нь ЛэндМН гарч ирснээр анхны 200,000 төгрөгийн зээлийн эрх авч, улмаар зээлийн эрх нэмэгдэж, 2025 онд бизнесийн зээл авах боломж бүрдсэн.

Тухайн үед засвар, шинэчлэл хийх шаардлага гарч нэмэлт санхүүжилт хэрэгтэй болсон. ЛэндМН-ээс боломжийн нөхцөлтэй зээл авах боломж гарч ирсэн нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн дэмжлэг болсон. Тэр санхүүжилтээр цэцэрлэгтээ засвар хийж, ханын материалыг эко хавтангаар сольсон. Мөн улсын санхүүжилтээр багш, ажилчдын цалинг олгодог ч зарим үед санхүүжилт хугацаандаа орж ирэхгүйгээс хүндрэл үүсдэг тул ЛэндМН-с шуурхай зээл авах нь үйл ажиллагааг тогтвортой явуулахад чухал үүрэгтэй байдаг.

Ерөнхийдөө том хэмжээний зээлээ банкнаас авдаг бол өдөр тутмын болон гэнэтийн жижиг, яаралтай санхүүгийн хэрэгцээ гарсан үед ЛэндМН нь үр дүнтэй дэмжлэг болдог гэж үздэг.

Эмэгтэй хувцасны дэлгүүр эрхлэгч

Анх

Ковидын үед онлайн худалдаагаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан. Эхний бараагаа татахдаа өөрт байсан багахан хэмжээний мөнгө, ковидын үед улсаас иргэн бүрт олгосон 300 мянган төгрөг, мөн нөхрийнхөө мөнгийг нийлүүлж ашигласан.

Анх үйл ажиллагаагаа 10 м² талбайгаас эхэлж байсан бөгөөд хүргэлтээ хүртэл өөрөө хийдэг байлаа. Эхэндээ нэг загвараас ганцхан ширхэгийг л авчирдаг байсан бол одоо нэг загвараас олон тоогоор татан авчирч чаддаг болсон.

Санхүүгийн бэрхшээл мэдээж үе үе гардаг. Жишээлбэл, зарим үед карго бууж, барааны төлбөр гэнэт нэхэгддэг. Тийм үед аппликэйшнаараа маш богино хугацаанд зээл авах боломжтой байдаг нь их хэрэгтэй байдаг.

Хувиараа бизнес эрхэлж байгаа жижиг бизнес эрхлэгч бидний хувьд барьцаа шаардахгүй, хугацаа урт, хүү харьцангуй боломжийн, мөн дансны хуулгаараа онлайнгаар зээлээ судлуулаад 100 сая хүртэл төгрөгийн зээл авах боломжтой байдаг нь маш том давуу тал болдог.

Үүний ачаар би улирал алдалгүй бараагаа татан авч чаддаг болсон. Жишээлбэл, шинэ жилийн үеэр бараагаа цагтаа татаж авч чадна гэдэг нь борлуулалт нэмэгдэхэд маш чухал нөлөөтэй.



Харилцагчдын бодит түүхээс



Захиалгат тавилгын бизнес эрхлэгч:

Бид “Чанар тавилга захиалга” нэртэйгээр Монгол гэрийн тавилгыг орчин үеийн загвартайгаар, гэрийн өндөр болон хэмжээнд нь тохируулан захиалгаар хийж, айл өрхүүдэд суурилуулж өгдөг.

Анх том хүүгийн маань 1 насны төрсөн өдөр болох гэж байсан бөгөөд 10 хоногийн дотор 3 сая төгрөг олох шаардлагатай болж, түүнийгээ тавилгын захиалга авч хийгээд амжилттай олж чадсан. Хэрэглэгч маань маш өндөр сэтгэгдэлтэй үлдсэн нь бидэнд улам их урам өгсөн.

Орон сууцны тавилга хийдэг компаниуд олон байдаг. Харин Монгол гэрт амьдардаг айл өрхүүдийн хувьд тав тухтай амьдрахад тохирсон тавилга маш чухал байдаг учраас бид Монгол гэрийн тавилгад илүү төвлөрч ажиллаж эхэлсэн.

Ажил эхлэх үед тоног төхөөрөмж болон санхүүгийн асуудал их байсан. Анх хүүхдийнхээ хадгаламжийн мөнгийг барьцаалж зээл авч, хоёр ширхэг дрилл худалдан авч ажлаа эхлүүлж байсан. Мөн энд тэндээс хуучин тоног төхөөрөмж худалдан авч хэсэг хугацаанд ашигласан.

Харин үйл ажиллагаагаа дараагийн түвшинд гаргахын тулд ЛэндМН-ээс бизнесийн зээл авч, тоног төхөөрөмжөө бүрэн шинэчилсэн. Тоног төхөөрөмжийн хүчин чадал нэмэгдсэнээр үйлдвэрлэл маань мэдэгдэхүйц өссөн. Одоогоор сард Монгол гэрийн иж бүрэн тавилгын 20 гаруй захиалга авч, гал тогооны тавилга болон бусад захиалгатай нийлээд нийт 40–50 айлын захиалга гүйцэтгэдэг болсон.

Өмнө нь цалингийн зээл авахын тулд олон шат дамжлага, бичиг баримтын дараа арай гэж зээл авч чаддаг байсан бол энэ удаа ямар ч хүндрэл, дарамтгүйгээр зээлээ авсан. Зээл батлагдсан тэр өдөртөө үйлдвэрлэлд хамгийн хэрэгцээтэй байсан тоног төхөөрөмжүүдээ худалдан авч чадсан.

Одоо ашиглаж байгаа машиныг ч мөн жилийн өмнө авсан зээлээрээ худалдан авсан бөгөөд ажлын бүтээмж 20–30 хувиар илүү хурдан, үр дүнтэй болсон гэж хэлж болно. ЛэндМН-ээс зээл авснаас хойш манай ажлын хүчин чадал, үйл ажиллагааны цар хүрээ нийтдээ 5 дахин нэмэгдсэн.

Үндэсний хувцасны брэнд үүсгэн байгуулагч:

2015 онд “Уужим” брэндийг үүсгэн байгуулж, Монгол үндэсний дээлийг орчин үеийн өнгө аястай хослуулан урлаж, хүмүүст хүргэхийг зорин ажиллаж байна.

Бизнес маань тогтмол орлоготой явж байгаа ч Монголын уламжлалт зээлийн системд хангалттай үнэлэгддэггүй тал бий. Ихэнх тохиолдолд зээл авахын тулд заавал барьцаа хөрөнгө шаарддаг.

Үнэндээ тийм хэмжээний барьцаа хөрөнгөтэй байсан бол заавал зээл авах шаардлага ч гарахгүй шүү дээ.

Ийм үед би ЛэндМН-ийн бизнесийн зээлийн талаар олж мэдсэн. Өөрийн орлогын мэдээлэл дээр үндэслэн, олон төрлийн бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүйгээр маш хялбар байдлаар зээл авах боломжтой байсан. Авсан зээлээрээ шаардлагатай бараа материал худалдан авч, ажлын орчноо сайжруулсан. Үүний үр дүнд захиалгын тоо нэмэгдэж, үйл ажиллагаа маань илүү тогтвортой, урагштай явж байна. Мөрөөдлөө бодит ажил болгоход ЛэндМН надад томоохон дэмжлэг үзүүлсэн гэж боддог.





Санхүүгийн боловсрол

Санхүүгийн байгууллага байна гэдэг нь зөвхөн санхүүжилт олгох үйл ажиллагаагаар хязгаарлагдах ойлголт биш юм. Бидний харилцагчид бол үйл ажиллагааны маань гол төв бөгөөд тэдний санхүүгийн мэдлэг, боловсрол нь бидний үйл ажиллагаатай салшгүй уялдаа холбоотой. Харилцагчид санхүүгээ илүү оновчтой удирдаж чадсанаар тогтвортой өсөж хөгжих нөхцөл бүрдэнэ.

Олон жижиг бизнесүүд зөвлөгөө, нийгмийн дэмжлэг, албан ёсны бизнесийн боловсролын хүртээмж дутмаг байдлаас шалтгаалан тодорхой сорилтуудтай тулгардаг. Иймд бид санхүүгийн мэдлэг болон дэмжлэг шаардлагатай бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор Монголын Бизнесийн Зөвлөл (BSM)-тэй хамтран “БЖДБ эрхлэгчдийг чадавхжуулах: Нийгэм, Санхүү, Инноваци” арга хэмжээг зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээнд хувийн хэвшлийн удирдлагууд, санхүүгийн байгууллагууд, академичид болон бодлого боловсруулагчид нэг дор цугларч, Монгол Улсын БЖДБ-үүдийг бэхжүүлэх боломжит шийдэл, арга замуудыг хэлэлцэв.

Хэлэлцүүлгийн гол зорилго нь нийгмийн оролцоо, хүртээмжтэй санхүүжилт, дижитал инновацыг дэмжих замаар БЖДБ-ийн илүү тогтвортой экосистемийг бүрдүүлэхэд чиглэв. Мөн үндсэн сэдвүүдэд Монголын эдийн засгийн чиг хандлага, БЖДБ санхүүжилтийн стратеги, татварын мэдлэг, мөн финтек технологиор дамжуулан санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох боломжуудыг хамран ярилцлаа.

Энэхүү хамтын ажиллагаа нь бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан бөгөөд түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн нэг чухал алхам болж чадлаа. Бизнес эрхлэгчдийн мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэхийг дэмжих нь бидний нийгэмд үзүүлэх нөлөөллийн чухал хэсэг мөн. Иймд цаашид бид санхүүгийн боловсрол, бизнесийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ижил төстэй арга хэмжээг тогтмол зохион байгуулж, бизнес эрхлэгчдийг санхүүгийн боловсролыг дэмжин ажиллахаар төлөвлөж байна.





Харилцагчийн эрхийг хамгаалах нь

Харилцагчийн эрхийг хамгаалах нь зөвхөн дүрэм журам мөрдөх шаардлага биш, харин харилцагчид бидэнд итгэх итгэлийн үндэс юм. Бичил бизнесийн хувьд анх удаа зээл авах нь эрсдэл ихтэй эсвэл тодорхой бус санагдах нь түгээмэл. Иймээс бид бүтээгдэхүүн болон үйл ажиллагаа бүрээ ил тод, шударга, хариуцлагатай байхаар зорин ажиллахыг эрхэмлэдэг.

Эдгээр зарчмууд нь манай дижитал зээлийн загварт шингэсэн бөгөөд бүтээгдэхүүн боловсруулах, зээлийн нөхцөлүүдийг харилцагчдад ойлгомжтойгоор танилцуулах, мөн харилцагчдын санхүүгийн аяллын туршид шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд анхааран ажилладаг. Түүнтэй холбогдуулан, бид харилцагчийн авч буй үйлчилгээний чанарыг тогтмол хянах зорилгоор 2025 онд Харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ (CSAT)-г хэмжих системийг болон Net Promoter Score (NPS) буюу харилцагчид манай үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бусдад санал болгох магадлалыг хэмжих үнэлгээний системийг ашиглаж эхлэв.

CSAT: 85%

Харилцагчийн сэтгэл ханамж өндөр

NPS: 63%

Харилцагчид манай үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бусдад санал болгох магадлал өндөр



Бидний хариуцлагатай санхүүжилтийн хүчин чармайлт олон улсад танигдаж чадлаа. ЛэндМН нь MicroFinanza Rating (MFR) буюу санхүүгийн байгууллагуудын санхүүгийн болон нийгмийн гүйцэтгэлийг олон улсын стандартаар үнэлдэг хараат бус үнэлгээний байгууллагаас олгодог Client Protection Certificate (CPC) буюу Харилцагчийг хамгаалах сертификат-ыг авсан. Энэхүү сертификат нь CERISE+SPTF-ийн боловсруулсан, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Харилцагчийн эрхийг хамгаалах стандартууд дээр үндэслэдэг. CERISE+SPTF нь санхүүгийн байгууллагуудын хариуцлагатай санхүүжилт, нийгмийн гүйцэтгэлийг хэмжих болон удирдах стандарт, аргачлалуудыг хөгжүүлдэг олон улсын байгууллагуудын хамтын санаачилга юм.

Эдгээр стандарт нь санхүүгийн байгууллагуудыг найман үндсэн зарчмын хүрээнд үнэлдэг. Үүнд ил тод байдал, шударга харилцаа, өрийн дарамтаас урьдчилан сэргийлэх, харилцагчийн өгөгдлийн нууцлалыг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх механизм зэрэг багтдаг.

Финтек салбараас дэлхийд анх удаа MFR-ийн Мөнгөн түвшний сертификат авснаар бид санхүүгийн салбарт ёс зүйтэй зээл олголтыг хэрэгжүүлж, харилцагчдын эрх ашиг, сонирхлыг хамгаалах тогтсон стандартыг мөрдөн ажиллаж байгааг баталгаажуулж байна. Мөн энэ нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж буйг илэрхийлэх чухал нотолгоо юм.

2X Challenge

Invest in women. Invest in the world.

2X Challenge-ийн шаардлагыг хангалаа

ЛэндМН нь Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагууд дундаас анх удаа 2X Challenge-ийн шалгуурыг хангасан байгууллага боллоо. 2X Challenge нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, жендэрийн тэгш байдлыг дэмжих зорилготой олон улсын хөрөнгө оруулалтын санаачилга юм.

ЛэндМН нь манлайлал, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтын портфолио гэсэн жендэрийн эрх тэгш байдлын гурван шалгуурын хүрээнд өндөр үзүүлэлттэй ажилласнаар уг шалгуурыг хангаж чадсан.

Монгол Улсад дижитал, барьцаагүй зээлийн үйлчилгээг нэвтрүүлэгч тэргүүлэгч байгууллагын хувьд ЛэндМН нь Developing World Markets (DWM) буюу хөгжиж буй орнуудын санхүүгийн байгууллагууд болон БЖДБ-үүдийг дэмжих зорилготой олон улсын нөлөөллийн хөрөнгө оруулалтын (impact investment) компаниас 4.25 сая ам.долларын санхүүжилт амжилттай татан төвлөрүүлсэн билээ. Энэхүү санхүүжилт нь DWM-ийн Монгол Улсад хийсэн 2X Challenge шалгуурыг хангасан анхны хөрөнгө оруулалт бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх, жендэрийн тэгш байдлыг дэмжихэд чиглэж байна.

Энэхүү амжилт нь ЛэндМН-ийн нөлөөллийн цар хүрээг тодотгож, эмэгтэйчүүдийн удирддаг бизнесүүдийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй бидний хүчин чармайлт Монгол Улсын санхүүгийн системд бодит, хэмжигдэхүйц нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Дүгнэлт

Бидний хамгийн анхны Нөлөөллийн тайлан нь зээл олголтын дараах бизнес эрхлэгчдэд хүрж буй үр нөлөөг хэрхэн тодорхойлж, хэмжих талаар чухал алхам болсон гэж харж байна. Санхүүжилт нь хэр их хүнд, хэр их хэмжээгээр, ямар бүлэг хүмүүст хүрч байгаа нь чухал хэдий ч бидэнд бизнес эрхлэгчид болон тэдгээрийн ард буй өрхүүдэд олгосон санхүүжилт бодит амьдрал дээр ямар үр дүн авчирч байгааг ойлгох нь мөн адил чухал ач холбогдолтой юм. Учир нь санхүүжилтийг тэлэх гэдэг нь зөвхөн бидэнд аль хэдийн байгаа тоон үзүүлэлтийг нэмэгдүүлэх асуудал биш, харин чанар, урт хугацааны үнэ цэнийг бий болгох тухай ойлголт билээ.

Үүнийг илүү тодорхой болгох зорилгоор бид бизнес болон өрхийн түвшний нөлөөллийн үзүүлэлтүүдийг нэвтрүүлсэн бөгөөд бизнес өсөлт нь орлогын тогтвортой байдал, хувийн санхүү болон амьдралын чанарт шууд нөлөөлдөг билээ. Эдгээр анхны үзүүлэлтүүд болон судалгаанд суурилсан аргачлалууд нь бидний суурь алхам болж байгаа бөгөөд цаашдын тайлагналд бид харилцагчдаас асуулга бөглүүлэх биш, илүү үр ашигтай, автоматжсан нөлөөллийн хэмжилтийн системийг хөгжүүлэхийг зорьж байна.

Ирээдүйд бид нөлөөллийн зарчмуудыг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх түвшинд улам бүр гүнзгий шингээж, өгөгдлийн чанар, ил тод байдал, засаглалыг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллана.

Энэхүү Нөлөөллийн тайланг бид төгсгөлийн цэг бус, харин суурь эхлэл юм. Бид хүртээмжтэй, хариуцлагатай, харилцагч төвтэй байдлаа хадгалснаар Монгол Улсын тогтвортой хөгжлийн чухал хэсэг болох санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тууштай хувь нэмрээ оруулсаар байх болно.



(976) 7707-0101
www.lend.mn

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
3-р хороо, Сөүлийн гудамж,
"Алтан Жолоо Тауэр", 10 давхар